

ИНЖЕНЕРИЙН ТӨХӨӨРӨМЖЛӨЛИЙН БЭХЛЭЛТИЙН БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

А.БААТАРЗААН /ҮБХИС-ийн БХУА-ийн магистрант, хошууч/

А.ЭНХЖИН /ҮБХИС-ийн БХУА-ийн магистрант, ахмад/

Түлхүүр үг: Байлдаан, инженерийн хангалт, бэхлэлт, төхөөрөмжлөл, цэргийн хамгаалалт, өөрчлөлт, мотобуудлагын батальон

Key words: The battle, engineering supplies, fortification, military protection, motorized rifle battalion.

Оршил

Цэргийн галын хүчний төвлөрлийн хувьд хуурай замын цэргийн бүлэглэлд гол цохилт хийх чиглэлээс нэн цэцтэй зэвсгээр онц чухал объектуудад хийх цохилтод, зэвсэгт тэмцлийн голлох хүчин зүйлийн хувьд автомат зэвсэг, хүнд техникээр зэвсэглэсэн хүнээс шинэ технологи автомат ажиллагаат зэвсгийн системд, тулалдааны талбарт ялалт байгуулах логикийн хувьд стратегийн ялалтын угтвар нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн тактикийн сөрөг талыг нэгэн зэрэг устгах стратегид, зэвсэгт мөргөлдөөний ялалтын шалгуур үзүүлэлтийн хувьд сөрөг талын зэвсэгт хүчнийг устгаж нутаг дэвсгэрийг эзлэн авахаас улс орныг эзлэн авахгүйгээр улс төр, цэргийн удирдлага, эдийн засаг, тээвэр, холбооны тогтолцоог алдагдуулахад шилжих төлөвтэй байна.

Хориглох байлдаанд инженерийн хангалтыг зохион байгуулахад бэхлэлтийн байгууламжуудын ашиглалт, хадгалалтын байдал нэгтгэл, анги, салбарууд өөрийгөө хамгаалах зэвсэгт тэмцэл явуулах үед, ялангуяа хориглолтод бэхлэлтийн байгууламжийг төхөөрөмжлөх, түүний хамгаалалтын битүүмжлэлийг сайжруулах, цэргийн бэхлэлтийн байгууламжийн зарим хийцийг боловсронгуй болгох талаас инженер-техникийн зарим нэгэн шийдлийг судлан гарган хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг авч үзлээ.

Үндсэн хэсэг

1: МББ ХОРИГЛОХ БАЙЛДААНД БЭЛТГЭХ ҮЕД ИНЖЕНЕРИЙН ХАНГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

МББ-ны хориглол байлдааны инженерийн

хангалтын үүрэг, зорилго: Орчин үед гол төлөв агаараас ноёлох ажиллагаа давамгайлсан нөхцөлд ердийн болон нэн цэцтэй зэвсгийн хөнөөлөөс бие бүрэлдэхүүн, зэвсэг, техникийг найдвартай хамгаалан хориглолтын бат тогтвортой байдлыг хангаж, тагнуулын хэрэгсэлээс хамгаалахад бололцоотой нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Хориглох байлдааны инженерийн хангалтыг амжилттай хэрэгжүүлэх нь ерөнхий цэргийн дарга нараас зөв, тодорхой шийдвэр гаргаж, цаг хугацаанд нь захирагсаддаа үүргээ хүргэн газар орон дээр нь тодотгож, зохион байгуулах, ялангуяа газар орныг инженерийн талаар тодорхой үүрэг, заалт өгч ажилласнаар хангагдана.

Байлдааны инженерийн хангалт гэдэг нь ерөнхий цэргийн байлдааны ажиллагааг амжилттай явуулахад тус дөхөм үзүүлэх, түүнийг хамгаалах, дайсны цэргийн байлдааны ажиллагааг хүндрүүлэх болон төлөвлөсөн арга хэмжээг нь саатуулах, тасалдуулахад чиглэгдсэн инженерийн хангалтын ажил, үүрэг, арга хэмжээнүүдийг хэлнэ.

Инженерийн хангалтын зохион байгуулах 7 үүрэг 3 арга хэмжээний хүрээнд МББ-ны хориглох байлдаанд инженерийн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Инженерийн төхөөрөмжлөлийн ажлын нэгдүгээр ээлжид: тасгийн байр, танк, ЯЦБМ /хуягт тээвэрлэгч/ болон бусад галын хэрэгслийн үндсэн галт байруудыг төхөөрөмжлөх; командын хянах/хянах/ байр, эмнэлгийн байрыг төхөөрөмжилж эхлэх; тасаг, тоот бүрд далдлалт байгуулах; рот /салаа/-ын тулгуурт байруудад

холбох шуудууг байгуулах; зэвсэг, техникийг өнгөлөн далдлах; салбаруудын завсар, хориглолтын жигүүр, гүнд саад байгуулах; хоёрдугаар цувраа /нөөц хүч/-ы танкийн болон ЯЦБМ-тай батальон /рот/-д галын заагуудыг төхөөрөмжилж, эдгээр заагууд болон сөрөг атакт хүч задлах заагуудад гарах хөдөлгөөний замуудыг бэлтгэх; ус хангах түгээх/ байрыг төхөөрөмжлөх ажлуудыг гүйцэтгэдэг.

Хоёрдугаар ээлжид: рот /салаа/-ын тулгуурт байруудыг гүйцээж төхөөрөмжлөх; танк, ЯЦБМ /хуягт тээвэрлэгч/, бусад галын хэрэгслийн бэлтгэл /түр/ галт байрууд, хуягт бүлгийн хүч хуралдуулах байр, галын заагуудыг бэлтгэх; батальоны хориглолтын районы холбох, харилцах шуудуунуудыг төхөөрөмжлөх; командын хянах /хянах/ болон эмнэлгийн байруудыг гүйцээж төхөөрөмжлөх; салаанд хөнгөн хоргодох байр, батальоны командын хянах байр, ротод хоргодох байр, техник, материал хэрэгслийн далдлалтуудыг байгуулах; батальоны хориглолтын район /ротын тулгуурт байр/-д хуурамч объектуудыг төхөөрөмжлөх; хориглолтын өвөр эгнээний өмнө, тулгуурт байруудын завсар болон жигүүрт нэмэгдэл саадуудыг байгуулах, маневр үйлдэх замыг бэлтгэх ажлуудыг гүйцэтгэх билээ. Цаашид: хориглолтын район /тулгуурт байр/-ы холбох, харилцах шуудууны сүлжээ, инженерийн саадын системийг өргөжүүлэх; салбаруудын маневрлах, тээвэрлэлт, татан гаргалтын замын сүлжээг нэмэгдүүлэх; хуурамч тулгуурт байр. холбох шуудуу, галт байрууд болон бусад объектуудыг төхөөрөмжлөх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

2 ИНЖЕНЕРИЙН ТӨХӨӨРӨМЖЛӨЛИЙН БЭХЛЭЛТИЙН БАЙГУУЛАМЖ ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ:

Хэрвээ цагийн байдлын таатай нөхцлийг ашиглан нийт бүрэлдэхүүнд блиндаж, хөнгөн маягийн хорогдох байр, техникт далдлалт бэлтгэн төхөөрөмжилбөл эсрэг талын нэн цэцтэй болон цөмийн зэвсгийн хөнөөлд өртөгдөх нь харьцангуйгаар 15 ба 20 дахин буурч болно.

Инженерийн төхөөрөмжлөлийн

ажлуудаас хамгийн их ажлын багтаамжтай, хүн хүч хэрэгсэл ихээр шаарддаг бэхлэлтийн төхөөрөмжлөлийг боловсронгуй болгох зарим инженер-техникийн шийдлүүд байна. Үүнд:

- Бэхлэлтийн төхөөрөмжлөлийн хамгаалалт түүнийг орлуулах талаар;

- Удирдлагын байр, траншей, окопыг далдлалтын байгууламжийг боловсронгуй болгох;

- Байлдааны инженерийн хангалтын онол, практикийн хөгжил нь түүхийн бүхий л үед энэ төрлийн хангалтын үүргийг зөвхөн инженерийн цэргийн анги, салбарууд төдийгүй харин бусад төрөл мэргэжлийн цэргээс гүйцэтгэж ирснийг харуулдаг.

Орчин үеийн нөхцөлд төрлийн цэргийн анги, салбаруудаас ерөнхий цэргийн байлдааны инженерийн хангалтын үндсэн үүргийг гүйцэтгэх хувь нэмэр тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа билээ.

Өндөр маневрлаг байлдааны ажиллагаанд анги, салбарууд өөрийн чиглэл бүрд бие даан байлдааны инженерийн хангалтын чухал үүргүүд, тухайлбал эзлэн хориглож буй байр, районы бэхлэлтийн төхөөрөмжлөл, цувааны зам бэлтгэх, ялангуяа зайнаас минажүүлсэн системээр тавьсан саадыг туулах, усан саадыг гатлах ажиллагааг зохион байгуулах болдог.

Инженерийн хангалтын үүргүүдээс хамгийн их ажлын багтаамжтай, цаг хугацаа, хүн хүч хэрэгсэл шаардсан ажил нь байр, районы бэхлэлтийн асуудал байдаг бөгөөд энэ ажлыг хэрхэн түргэн, шуурхай, оновчтой, зөв зохион байгуулж чадсанаар бие бүрэлдэхүүн, зэвсэг, байлдааны болон тусгай зориулалтын техник, эд хэрэгслэлээ дайсны хөнөөлийн хэрэгслээс хамгаалах, хадгалан үлдэх нөхцөлийг бүрдүүлж, байлдах боломж болон амьдрах чадвараа нэмэгдүүлэх болно.


Иймд бэхлэлтийн төхөөрөмжийн ажлыг зохион байгуулах үеийн захирагч, дарга нарын ажиллагаанд шинжилгээ хийх, тэдний ажлын дараалал, үүргийн хуваарилалтыг тодотгох, бэхлэлтийн төхөөрөмжлөлийн ажлыг тооцоолох аргуудыг гаргах, хээрийн бэхлэлтийн

байгууламжийн хамгаалалтын бүтэмжийг дээшлүүлэх, бэхлэлтийн байгууламжийн хийцийг бэлтгэх, зөвлөмж боловсруулах, гарч байгаа зарим алдаа дутагдлыг засаж залруулах шаардлага гарч байгаа тул энэхүү бүлэгт дээрх асуудлуудыг шинжилсэн.

Төрөл бүрийн хээрийн сургууль, гаралтууд болон дадлагын хичээлүүдэд хийсэн ажиглалт, судалгаа, мөн түүнчлэн сүүлийн арваад жилд болсон зэвсэгт мөргөлдөөн, нутаг дэвсгэрийн маргаанд асуудал, орон нутгийн дайн, энхийг сахиулах хүчний болон алан хядлагын эсрэг ажиллагаанд оролцож байгаа цэргийн ажиллагаанаас харахад орчин үед цэргийн бэхлэлтийн үүрэг, ач холбогдол бүр ихээр өссөөр байна.

Иймд инженерийн төхөөрөмжлөлийн ажлуудаас хамгийн их ажлын багтаамжтай, хүн хүч хэрэгсэл ихээр шаарддаг бэхлэлтийн төхөөрөмжлөлийг боловсронгуй болгох зарим инженер-техникийн шийдлүүдийг санал болгож байна.

Орчин үеийн ерөнхий цэргийн байлдаанд үүсэж болох байлдааны ажиллагааны янз бүрийн нөхцөлд танк, ЯЦБМ, хуягт тээвэрлэгч болон байлдааны бусад техникүүд галт байраа олон дахин өөрчлөх шаардлага гардаг тул тэдгээрийн нууцаар шилжих нөхцөлийг хангах харилцах шуудууг төхөөрөмжилж болох юм.




Зураг 1.

Цаг хугацаа байгаа нөхцөлд танк /ЯЦБМ, хуягт тээвэрлэгч г.м/-д хязгаарлагдмал буудлагын сектортой далдлалт бүхий окопыг төхөөрөмжилж болно. Окопыг газар оронд сайн өнгөлөн далдалж байрлуулах бөгөөд голдуу хажуу зах, жигүүрээс буудахаар баримжаалсан байвал зохино.

1. Танкийн салааны тулгуур байр

Цаг хугацаа байгаа нөхцөлд танк /ЯЦБМ,

хуягт тээвэрлэгч г.м/-д хязгаарлагдмал буудлагын сектортой далдлалт бүхий окопыг төхөөрөмжилж болно. Окопыг газар оронд сайн өнгөлөн далдалж байрлуулах бөгөөд голдуу хажуу зах, жигүүрээс буудахаар баримжаалсан байвал зохино. Танк /ЯЦБМ, хуягт тээвэрлэгч г.м/-ийн галт байр /окоп/-д тухайн салбар газар шорооны техник хэрэгсэлтэй үед тийм байгууламжийг нуувч-окоп болон 100м хүртэл урттай шороон далан, эсвэл нэг талдаа хамгаалалтын шороотой гуу хэлбэртэйгээр төхөөрөмжилж болно. Энэ нь танк /ЯЦБМ, хуягт тээвэрлэгч г.м /-ийн нууц маневрыг хангаж байх болно.



Зураг 2.

Шороон далан /хамгаалалтын шороо/-ны өндрийг 1,5м-ээр авч, түүн дээгүүр гал явуулахаар төхөөрөмжлөх хэрэгтэй.

Танк /ЯЦБМ, хуягт тээвэрлэгч г.м/-ийг бүрэн далдлахын далангийн өндөр 2,5м-ээс багагүй байх тул зарим газар 1м-ийн өндөртэй хэд хэдэн буудлагын талбайг бэлтгэсэн байвал зохино.

Далангийн хэлбэр дүрсийг зурагт зааснаар дугуйрсан хэлбэртэйгээр хийвэл газар орны нөхцөлтэй зохицож гал явуулах боломжийг илүү олгоно. Танк /ЯЦБМ, хуягт тээвэрлэгч г.м/-ийн галт байранд окопыг төхөөрөмжлөх ба харин цаг хугацаа болон газар шорооны техник байгаа үед даланг төхөөрөмжлөх болно.

Сүүлчийн тохиолдолд нуувчийг далангийн ард ухахгүй.

Хэрвээ, галын заагууд нь сөрөг атакын хүч задлах зааг болон мотобуудлага, танк эсэргүүцэх салбарын бэлтгэл галт байртай давхцаж байвал шороон даланд буудлагын болон танк эсэргүүцэх хэрэгсэл, миномётын окопыг төхөөрөмжилж болно.

Танкийн салбаруудад эзэлж буй байраа танкийн бульдозерын зүүх тоноглолыг ашиглан төхөөрөмжлөнө.

Танк /ЯЦБМ, хуягт тээвэрлэгч г.м/-ийн нуувч-окоп нь шороон далангаас 50м-ийн зайнд байхаар төхөөрөмжлөх ба түүнд 4м-ийн урттай, 14–16см-ийн диаметр бүхий шургаагаар призм байдлаар хөдөлгүүрийн дээд хэсгийг халхлахаар байрлуулна.

Гарах шорооны эзлэхүүн 90м³ байх ба төхөөрөмжлөхөд танкийн бульдозероор 0,75 маш-цаг, 45 хүн-цаг гүйцэтгэж, түүнд 1,5м³ модон материал, 5кг төмөр утас шаардагдана.

Гэвч ийм маягийн байгууламж нь байлдааны техникийн бүтэмжийг дээшлүүлэх хэдий ч цагийн байдал, газар орны нөхцөл, мөн цаашилбал инженерийн газар шорооны техникийн боломж байгаа үед л зөвхөн илүү үр дүнтэй байх болно.

Байлдааны үндсэн төрлийн техник /танк, ЯЦБМ, хуягт тээвэрлэгч, автомашин/-ийн окопуудын төхөөрөмжлөх хугацаа, норматив, ажлын багтаамж нь өөр, тэдгээрээс гарах шорооны эзлэхүүн янз бүрийн байдаг тул ялангуяа маневрын хориглолтын засварын заагуудыг төхөөрөмжлөж буй инженер-төхөөрөмжийн салбарын үүрэг гүйцэтгэлд хүндрэлтэй байдаг.

Энэ байдлаас гарахын тулд дээр дурдсан техникуудийн суурин ухмалын оврын хэмжээнд судалгаа хийж, нэгдсэн нэг ижил хэмжээтэй суурин ухмал төхөөрөмжилж болох юм гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Эдгээр суурин ухмалын үндсэн хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1.
Үндсэн төрлийн байлдааны техникийн далдлалтын хэмжээ

№	Далдлах объектын нэрс	Үндсэн окоп далдлалтын хэмжээ				Гарах шороо, м ³	Төхөөрөмжлөхөд шаардагдах	
		Өргөн, м	Урт, м	Орц, м	Гүн, м		Хүн-цаг	Маш-цаг,
1	Танк	4	5	1,7	1	28	30	0,6 маш/цаг /БТУ/ 5 хүн/цаг
2	Явган цэргийн байлдааны машин /БМП/	3,5	5,5	2,5	1	29	32	0,3 маш/цаг /ПЗМ/ 8 хүн/цаг
3	Хуягт тээвэрлэгч /БТР/	3,5	5,5	5	1,5	48	65	0,6 маш/цаг /ПЗМ/ 12 хүн/цаг
4	Автомашин /Зил-131/	3	6	6	2	82		1,7 маш/цаг /бульдозер / 11 хүн/цаг

Хүснэгт 2.

Универсал окопын үндсэн хэмжээ

№	Далдлах объектын нэр	Үндсэн окоп далдлалтын хэмжээ				Гарах шорооны м ³	Төхөөрөмжлөхөд шаардагдах, маш цаг	
		Өргөн, м	Урт, м	Орц, м	Гүн, м		Хүн цаг	0,4/07 маш/цаг
1	Универсал окоп	4	5,5	5	1	32	8 хүн цаг	

Дээрх байдлаар төхөөрөмжлөхийн ач холбогдол нь тухайн төхөөрөмжилсөн байрлалд байлдааны ямар ч техниктэй салбар ирж байрлаж болох бөгөөд тактикийн жижиг салбаруудад хүч нэмэгдүүлэн өгсөн байгаа байлдааны үндсэн техникүүдийг ч далдлах болно.

Батальоны хэмжээний багтаамжтай хориглолтын байр, таслах зурвас/зааг/-ыг инженер-төхөөрөмжийн салбарын хүчээр батальоны универсал хориглолтын районыг төхөөрөмжилдөг.

Батальоны универсал хориглолтын район гэдэг нь инженер-төхөөрөмжийн салбарын хүчээр маневрын хориглолтын завсрын заагууд болон таслах зурвас/зааг/-т урьдчилан бэлтгэгдсэн батальоны хориглолтын район байх бөгөөд түүний бэхлэлтийн төхөөрөмжийн шинж байдал нь 45–50 ширхэг танк, ЯЦБМ, хуягт тээвэрлэгчийн универсал окоп бүхий 300–400м-ийн траншейг /нийт 5–6км

урттайгаар/ төхөөрөмжлөсөн байж болно. Зураг-т батальоны универсаль хориглолтын районы ерөнхий байдлыг үзүүлэв.



Зураг 3.

Ийм багтаамжтай бэхлэлтийн төхөөрөмжийн ажлыг орон тооны зэвсэглэлдээ хорооны газар шорооны машин ПЗМ-2 1 ширхэг, цэргийн нэг шанагатай экскаватор ЭОВ-4421 2 ширхэг, суурийн ухмалын машин МДК-2 1 ширхэг бүхий инженер-төхөөрөмжийн салааны хүчээр төхөөрөмжлөхөд нэг хоног шаардлагатай байна.

Харин дээрх батальоны универсал районы инженерийн I ээлжийн багтаамжтай болтол гүйцээж төхөөрөмжлөхөд ердөө л 10-12 цаг шаардагдах болох юм.


Энэ нь ялангуяа, маневрын хориглолтын үед заагаас заагт шилжилт хөдөлгөөн үйлдэж буй жижиг бүлэг, салбаруудын хувьд ажлын их багтаамжтай, цаг хугацаа болон хүч хэрэгсэл их шаарддаг бэхлэлтийн төхөөрөмжлөлийг бэлтгэх асуудлыг хөнгөлж өгөх болно.

Орчин үед нэн өндөр цэцтэй зэвсгээс бие бүрэлдэхүүн, зэвсэг техникийг хамгаалахын тулд тэдгээрийг тараан байрлуулах, төхөөрөмжлөлийн ажил болон өнгөлөн далдлалтын цогцолбор арга хэмжээнүүдийг гүйцэтгэх хэрэгтэй болж байна.

Цөмийн зэвсгийн галт хэрэгсэл, нейтроны илүүдэл цацрагийн үйлчлэлээс бэхлэлтийн байгууламжийн хамгаалах шинж чанарыг дээшлүүлэхийн тулд хамгаалалтын шороон хучилтын зузааныг хучилттай щельд 60см хүртэл, бие бүрэлдэхүүнийг хамгаалах блиндаж, хорогдох байранд 1, 3м хүртэл, харин удирдлагын байранд 1,8м хүртэл байхаар ихэсгэх хэрэгтэй. Эдгээр бүх байгууламжид

орох орцны өмнө 3м-ээс багагүй урттай, хучилттай хэсгийг зайлшгүй төхөөрөмжлөх хэрэгтэй.

Окоп, нуувчны дээд талын хэсгийг галт хэрэгслийн үйлчлэлээс байлдааны техникийг хамгаалахын тулд хучилтын хийц ба шороон бүрхүүлийн зузаан 30-35см байхаар авна.



Зураг 4.

10 тн-ны даацтай контейнерт бэхлэлтийн төхөөрөмжлөлийн дотоод төхөөрөмж, тоноглолыг байрлуулж, суулган түүн дотор ажиллах, амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажлын ширээ, сандал, ор /наар/-ыг бэхэлж болно.

Контейнерийн оврын хэмжээ, багтаамж нь удирдлагын байранд төхөөрөмжилдөг үйлдвэрийн хийцийн КВС-У, КВС-А г.м хорогдох байртай бараг ижил юм. Хүнд нь 2,1тн байдаг нь цэргийн хэрэгт ашиглаж байгаа ямар ч маркийн өргөх хэрэгсэл, кранаар

өргөж болохоос гадна тээврийн зориулалттай машинаар тээвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Иймд уул хорогдох байрны хийцийг олон дахин ашиглах үүднээс өнөө үед зах зээлд ихээр орж ирж байгаа контейнерийг тоноглон ашиглаж болох юм.


Мөн түүнчлэн төрөл бүрийн олон улсад ашиглаж буй бэхлэлтийн хийц байгууламжийг өөрийн оронд бэлтгэн үйлдвэрлэж ашиглах бүрэн боломжтой байна.

Газар орны хөрсний харилцан адилгүй байдлаас болж, хатуулаг ихтэй хөрсөнд, ялангуяа өвлийн улиралд бэхлэлтийн төхөөрөмжийн ажил тогтоосон цаг хугацаандаа хүрдэггүй тал байдаг. Энэ байдлаас гарахын тулд дараах зөөврийн, олон дахин хэрэглэж болох, угсардаг байгууламжийг санал болгож байна.

30–40 см-ийн диаметр бүхий хөнгөн цагааны хайлшаар хийсэн энэ байгууламж нь даавуун сараалжин байгууламжийн төрөлд хамаарагдах болно. Түүний үндсэн элементүүд нь: өөр хоорондоо ижилсүүлэн сольж, хэрэглэх боломжтой хөнгөн цагаан хоолойн элементэн сараалж, даавуун бүрхүүл, савлах уут, баглаа эдгээр болно.

Угсрах болон хураахад хялбар, хөнгөн, овор зай, бага эзэлдэг, тодорхой хэмжээний тогтворшил сайтай, бат бэх чанартай. Дээрх элементүүдийг ашиглан буудагчийн окоп, гранатомётчны окоп, пулемётчны окоп, тасгийн щель, экипажийн блиндаж болон траншейны хананы доторх хэсгийг бүрж, доторлох зэрэг олон янзаар ашиглаж болох юм.

Энэхүү даавуун сараалжин байгууламжийн тусламжтайгаар бие бүрэлдэхүүн өөрийгөө дайсны хөнөөлийн хэрэгслэлээс тодорхой хэмжээгээр хамгаалахаас гадна төрөл бүрийн буудлагын зэвсгээс буудлага явуулах тааламжтай нөхцөл бүрдүүлж болохоор байна. Хориглолтод, ялангуяа маневрын хориглолтод инженерийн хувьд бүрэн бэлтгэгдээгүй завсрын зааг, зурвас дээр газар орныг бэлтгэж, төхөөрөмжлөх үед дээр дурдсан байгууламж үүргээ биелүүлэх болно.



Зураг 5. Хүн нэг бүрийн болон пулемётчин, хоёр буудагчийн даавуун сараажилжин байгууламжийн ерөнхий байдал

Дүгнэлт

Шинжлэх ухаан техникийн хөгжил дэвшлийн дагуу цэрэг, армийн зэвсэглэл, хөнөөлийн хэрэгслэлүүдийн хөнөөх хүчин чадал нь хэмжээлшгүй нэмэгдэж байлдааны ажиллагаа улам бүр хөгжиж байна.

Хориглох байлдаанд хамгийн чухал асуудал дайсны галын цохилт, нэн өндөр цэцтэй зэвсгээс хэрхэн хамгаалах учрах хохирлы хэрхэн багасгах нь газар орон объектыг инженерийн талаар бэлтгэж, төхөөрөмжлөх шаардлагатай болсон.

Энэ нь бие бүрэлдэхүүн, техникт хамгаалалтын байгууламжуудыг улам боловсронгуй цаг алдалгүй бэлтгэж, үйлдвэрлэж цэргийн амьдрах, байлдах чадварыг нэмэгдүүлж, бат тогтвортой хориглолтыг буй болгох юм.

Хээрийн бэхлэлтийн байгууламжийг боловсронгуй болгох зарим асуудлаас бэхлэлтийн төхөөрөмжлөлийн ажлыг зохион байгуулах, төлөвлөх, тооцоолох асуудлууд орно.

Иймээс бэхлэлтийн төхөөрөмжлөлийн ажлыг тооцоолох аргуудыг гаргах, хээрийн бэхлэлтийн байгууламжийн хамгаалалтын бүтэмжийг дээшлүүлэх, бэхлэлтийн байгууламжийн хийцийг бэлтгэх ажиллагаануудад зөвлөмж боловсруулж, дараах байдлаар шинжилсэн болно.

Иймээс бэхлэлтийн байгууламжийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж, орчин үеийн хөнөөлийн хэрэгслэлээс хамгаалах шаардлагыг хангасан, авсаархан хямд төсөр, гарын доорх олдоц ихтэй материалаар, богино хугацаанд төхөөрөмжлөж болохуйц байгууламжийг боловсронгуй болгох онол, практикийн асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлага бий болсон гэж үзэж байна.

Ашигласан материал:

1. Байлдааны дүрэм 2/100 БХИС УБ хот 2016 он.
2. Цэргийн инженерийн бэлтгэл Б.Мөнхсайхан 2005 он.
3. Д.Мягмар "Говь талын нөхцөл дэх хөдөлгөөнт хориглолт " БХИС УБ хот 2002 он.
4. Б.Түмэн "Маневрын хориглолт" БХИС УБ 2003 он.
5. Б.Түмэн "Тактик байлдах урлаг" УБ 2021 он.
6. Н.Наран-Очир "Ойлголт, аргачлал, тайлбар" УБ 2021 он
7. Б.Мөнхсайхан "Байр, районы бэхлэлтийн төхөөрөмжлөл" УБ хот 2002 он.
8. Г.Өлзийбат, Б.Мөнхсайхан нар "Цэргийн инженерийн бэлтгэл" БХИС 1999 он.